



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН САЙДЫН  
ТУШААЛ

2013 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.17 дахь заалт, "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбогдсон нарийвчилсан журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын шалгуур үзүүлэлт тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар, шингэрүүлсэн шатдаг хийн агуулахын шалгуур үзүүлэлт тодорхойлолтыг 3 дугаар хавсралтаар, шатахуун түгээх станцын шалгуур үзүүлэлтүүдийг 4 дүгээр хавсралтаар, шингэрүүлсэн шатдаг хий түгээх станцын шалгуур үзүүлэлтүүдийг 5 дугаар хавсралтаар, импортын мэдээ гаргах маятын загварыг 6 дугаар хавсралтаар, бөөний борлуулалтын мэдээ гаргах маятын загварыг 7 дугаар хавсралтаар, жижиглэнгийн борлуулалтын мэдээ гаргах маятын загварыг 8 дугаар хавсралтаар, үлдэгдлийн мэдээ гаргах маятын загварыг 9 дүгээр хавсралтаар, Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч компаниудаас мэдээ тайлангаа Газрын тосны газарт ирүүлэх хуваарийг 10 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжидэд, Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Түлшний болдлогын хэлтэс /А.Эрдэнэпүрэв/-т, Газрын тосны газар /Г.Өлзийбүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, өргөдлийн загвар, материал бүрдүүлэх, дүгнэлт гаргах заавар батлах тухай" Үйлдвэр, худалдааны сайдын 2006 оны 197 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.ГАНХУЯГ

Бүртгэлийн дугаар 98

МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

*М. Ганхуяг*

2013 оны 09 сарын 20 өдөр

Уул уурхайн сайдын 2013 оны  
08 сарын 29-ны өдрийн 137 дугаар  
тушаалын 1-р хавсралт

## ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБОГДСОН НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ

УХА0380

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүн, тодруулбал бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг импортлох, бөөнөөр, жижиглэнгээр худалдах тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, мэдээ тайлан гаргах харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журам нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Барилгын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудад үндэслэж, тэдгээрт нийцсэн байна.

### Хоёр. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, эрхлэх үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ

2.1 Тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон огноо, хүчинтэй байх хугацаа, эзэмшигчийн нэр, үйл ажиллагааны төрөл, чиглэлийг тэмдэглэх бөгөөд уг тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлт, агуулах, түгээх станцыг бүртгэх зориулалт бүхий хавсралттай байна.

2.2 Тусгай зөвшөөрлийг дараах төрлөөр олгоно. Үүнд:

2.2.1. Импортлох; - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг импортлох;

2.2.2. Бөөний худалдаа эрхлэх - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг агуулахаас худалдах үйл ажиллагаа;

2.2.3. Жижиглэнгийн худалдаа эрхлэх - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг түгээх станцаас худалдах үйл ажиллагаа;

### Гурав. Тусгай зөвшөөрөл олгох, сунгах

3.1 Аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө энэхүү журмын Дөрөвт заасан материалын хамт, олгогдсон тусгай зөвшөөрлийг сунгуулах өргөдлөө Тав-д заасан материалын хамт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "Уул уурхайн яам" гэх/-д гаргана. Энэхүү журмын Зургаа-д заасан материалыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "Газрын тосны газар" гэх/-д гаргана.

Бүртгэлийн дугаар ..... 137

МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

М. Гүнжигмэл

2013 оны 11 сарын 20-ний өдөр



3.2 Тусгай зөвшөөрлийг Уул уурхайн яамны шийдвэрээр олгоно, хугацааг сунгана.

3.3 Газрын тосны газар нь өргөдөл гаргасан этгээдийн агуулах, шатахуун түгээх станцын техникийн дүгнэлтийг ажлын 20 хоногийн дотор гаргаж Уул уурхайн яаманд хүргүүлнэ.

3.4 Хэрэв шаардлагатай гэж үзвэл 3.3-т заасан хугацааг ажлын 10 хоногоор сунгаж болно.

3.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн агуулах, шатахуун түгээх станцын техникийн дүгнэлтийг үндэслэн Газрын тосны газрын шийдвэрээр бүртгэлийн гэрчилгээ олгож тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглүүлэх арга хэмжээ авна.

3.6 Агуулах, түгээх станцын гэрчилгээнд түүнийг олгосон он, сар, өдөр, дугаар, хүчинтэй хугацаа, эзэмшигчийн нэр, байршил, хүчин чадлыг тэмдэглэсэн байна.

3.7 Өргөдөл гаргасан этгээдийн өргөдөлд хавсаргасан материалд магадлан шинжилгээ хийх болон газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцыг газар дээр нь үзэж шалгах арга хэмжээний үед гарах зардлыг өргөдөл гаргагч хариуцна.

#### **Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал**

4.1. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг импортлох тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан бичиг баримтууд;

4.1.2. Мэргэжлийн холбооны гишүүн болохыг тодорхойлсон баримт бичиг;

4.1.3. Газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ /эх хувиар/

4.2. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:


4.2.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.4-т заасан бичиг баримтууд;

4.2.2. Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ;

4.2.3. Мэргэжлийн холбооны гишүүн болохыг тодорхойлсон баримт бичиг;

4.2.4. Агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, техникийн дүгнэлт, эсхүл түрээсийн гэрээнд заагдсан агуулахын техникийн дүгнэлт;

4.3. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:



4.3.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2-т заасан бичиг баримтууд;

4.3.2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан холбогдох шаардлагыг хангаж байгааг нотолсон бичиг баримт;

4.3.3. Мэргэжлийн холбооны гишүүн болохыг тодорхойлсон баримт бичиг;

4.3.4. Түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, техникийн дүгнэлт, эсхүл түрээсийн гэрээнд заагдсан түгээх станцын техникийн дүгнэлт;

### **Тав. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах, бүрдүүлэх материал**

Хугацаа сунгуулах өргөдлийг холбогдох материалын хамт тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө гаргана.

5.1 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

5.1.1 Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл;

5.1.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байсан талаарх Газрын тосны газрын тодорхойлолт;

5.1.3 Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт /бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгуулах тохиолдолд/;

5.1.4 Тусгай зөвшөөрлийн төрлөөс хамаарч дараах материалыг нэмж бүрдүүлнэ. Үүнд:

5.1.4.1 Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг импортлох тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ /эх хувиар/

5.1.4.2 Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад стандартын шаардлага хангасан агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, техникийн дүгнэлт, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ;/эх хувиар/

5.1.4.3 Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн жижиглэнгийн худалдаа эрхлэх жижиглэнгээр худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад газрын тосны бүтээгдэхүүний түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, техникийн дүгнэлт, эсхүл түрээсийн гэрээний хуулбар;

### **Зургаа. Агуулах, шатахуун түгээх станцын техникийн дүгнэлт гаргуулахад бүрдүүлэх материал**

6.1. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн агуулахын техникийн дүгнэлт гаргуулахад дор дурдсан бичиг баримтыг /эх хувиар эсхүл наториатаар гэрчлүүлсэн хуулбар/ бүрдүүлнэ. Үүнд:

6.1.1. Техникийн дүгнэлт хүссэн өргөдөл;

6.1.2. Улсын бүртгэлийн гэрчилгээ;

Бүртгэлийн дугаар .....137.....

МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

... Ш. Уриангидорь ...

20 13-ны 11-сарын 20-ний өдөр




- 6.1.3. Стандартын шаардлага хангасан агуулахын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ;
- 6.1.4. Нисэх онгоцны түлш хадгалах зориулалтын агуулахад Иргэний нислэгийн аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулах эрх бүхий байгууллагаас гаргасан дүгнэлт;
- 6.1.5. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсадын танилцуулга;
- 6.1.6. Хэмжүүр, хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулсан бичиг баримт;
- 6.1.7. Агуулах нь газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээний лабораторийн гэрчилгээ буюу итгэмжлэгдсэн лабораторитай байгуулсан гэрээ;
- 6.1.8. Галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ажлын байрны дүгнэлт;
- 6.1.9. Мэргэжлийн байгууллага боловсруулж улсын экспертизээр баталгаажуулсан агуулахын зураг төсөл, газар эзэмших зөвшөөрөл, улсын комиссоор хүлээн авсан акт;
- 6.1.10. Шатахууны савыг улсын бүртгэлд бүртгүүлсэн баримт;
- 6.1.11. Агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт;

6.2. Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн түгээх станцын техникийн дүгнэлт гаргуулахад дор дурдсан бичиг баримтыг /эх хувиар эсхүл наториатаар гэрчлүүлсэн хуулбар/ бүрдүүлнэ. Үүнд:

- 6.2.1. Техникийн дүгнэлт хүссэн өргөдөл;
- 6.2.2. Улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 6.2.3. Газрын тосны бүтээгдэхүүний түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ;
- 6.2.4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулсан бичиг баримт;
- 6.2.5. Галын аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ажлын байрны дүгнэлт;
- 6.2.6. Мэргэжлийн байгууллага боловсруулж улсын экспертизээр баталгаажуулсан агуулахын зураг төсөл, газар эзэмших зөвшөөрөл, улсын комиссоор хүлээн авсан акт;
- 6.2.7. Мэргэжлийн инженер, техникийн ажиллагсадын танилцуулга;
- 6.2.8. Шатахуун түгээх станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт;

### **Долоо. Газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрлийн нөхцөл**

7.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:



7.1.1 Чанарын хувьд Монгол Улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг импортлох;

7.1.2 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад импортолсон бүтээгдэхүүний нийлүүлэгч эх үүсвэр, тоо хэмжээ, нэр төрөл, үнэ, импортолсон боомт, чанарын талаар үнэн зөв мэдээллээ тухай бүр албан ёсоор хүргүүлнэ. /Маягт-5 дагуу/;

7.1.3 Мэдээ тайланг энэхүү журмын 7.1.2-т заасны дагуу гаргаж сар бүрийн 5-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр Газрын тосны газарт хүргүүлэх;

7.1.4 Төрийн эрх бүхий байгуулагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх;

### **Найм. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл**

8.1 Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

8.1.1 Компанийн нөөцийг тогтоосон хугацаанд бүрэн бүрдүүлэх;

8.1.2 Зориулалтын бус болон улсын комисс хүлээн аваагүй барилга байгууламжид газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалахгүй байх;

8.1.3 Агуулахад гэрчилгээ авч тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглүүлэх;

8.1.4 Үйлчилгээгээ өргөтгөх, салбар, цэг шинээр байгуулах зэрэг аливаа өөрчлөлт хийх тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр албан ёсоор урьдчилан мэдэгдэх;

8.1.5 Бөөний борлуулалтын талаарх үнэн зөв мэдээллээ улирал, сар, 7 хоног бүрээр гаргаж дараа сарын 5-ны дотор /Маягт-6 дагуу/, үлдэгдлийн мэдээг долоо хоног бүрийн Мягмар гаригт хот, аймаг бүрээр гаргаж /Маягт-8 дагуу/ эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр Газрын тосны газарт хүргүүлэх;


8.1.6 Төрийн эрх бүхий байгуулагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх;

### **Ес. Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл**

9.1 Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

9.1.1 Үйлчилгээгээ өргөтгөх, шинэчлэх зэрэг аливаа өөрчлөлтийг Газрын тосны газарт тухай бүр албан ёсоор мэдэгдэх;

9.1.2 Жижиглэнгийн борлуулалтын талаарх үнэн зөв мэдээллээ улирал, сар, 7 хоног бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор /Маягт-7 дагуу/, үлдэгдлийн мэдээг долоо хоног бүрийн Мягмар гаригт хот, аймаг бүрээр гаргаж /Маягт-8 дагуу/





эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан албан бичгээр Газрын тосны газарт хүргүүлэх;

9.1.3 Төрийн эрх бүхий байгуулагаас шаардсан бусад холбогдох мэдээ, тайланг заасан хугацаанд нь түргэн шуурхай, үнэн зөв гаргаж хүргүүлэх;

9.1.4 Газрын тосны бүтээгдэхүүний худалдаанд хязгаарлалт хийсэн тохиолдолд энэ тухай 24 цагийн дотор Газрын тосны газарт албан бичгээр мэдэгдэх;


9.1.5 Шинээр байгуулсан шатахуун түгээх станцад бүртгэлийн гэрчилгээ авч тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглүүлэх;

### Арав. Хяналт


10.1 Тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүргийн биелэлт, хэрэгжилтэнд Газрын тосны газрын биет төлөөлөгч хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд Уул уурхайн яамны төлөөлөл оролцоно.

10.2 Хяналт тавих эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн объект, агуулах, түгээх станцад саадгүй нэвтрүүлж, үзлэг шалгалт хийх нөхцөл боломжоор хангана.

ooOoo



Уул уурхайн сайдын 2013 оны  
0.8 сарын 29-ний өдрийн 171 дүгээр  
тушаалын 2-р хавсралт



## ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Эзэмшигчийн нэр: \_\_\_\_\_

ГТБА-ын байршил: \_\_\_\_\_

ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : \_\_\_\_\_

Удирдлагын нэр, албан тушаал: \_\_\_\_\_


Холбогдох утас: \_\_\_\_\_

д/д	Нэг. Эрх зүйн бичиг баримтууд	Бүрдэл	
1.	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, эзэмших газрын хэмжээ		
2.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, огноо		
3.	Батлагдсан зураг төслийн шифр, боловсруулсан байгууллага, огноо		
4	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ		
5	Бусад объектоос алслагдсан зай хэмжээ		
<b>Хоёр. Техник технологийн байдал</b>		<b>үзүүлэлтүүд</b>	
1.	Вагон эстакад		
д/д	Бүрэлдэхүүн	хэмжих нэгж	хүчин чадал, марк
1.1	Байгууламж	төмөр замын урт	м
		шат, тавцангийн урт	м
		гэрэлтүүлэг	ш, вт
		газардуулга	тайлбар
		ослын сав, суваг	м <sup>3</sup> , м


Бүртгэлийн дугаар .....137.....  
**МОНГОЛ УЛСЫН**  
**УУЛ УУРХАЙН ЯАМ**  
**ХУУЛБАР ҮНЭН**  
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг  
*М. Урэншмэг*  
 2013 оны 11 сарын 20-ний өдөр



1.2	Коллектор	ДТ	диаметр	мм	
			урт	м	
		автобензин	диаметр	мм	
			урт	м	
		бусад:	диаметр	мм	
урт	м				
шүүр, тунгаагуур			ш		
1.3	Ачих буулгах төхөөрөмж, /1 зэрэг/	нийт тоо		ш	
		дээгүүр буулгах		ш, м <sup>3</sup> /цаг	
		дээгүүр ачих		ш, м <sup>3</sup> /цаг	
		доогуур буулгах		ш, м <sup>3</sup> /цаг	
		доогуур ачих		ш, м <sup>3</sup> /цаг	
		газардуулга		тайлбар	
2.	Автоцистернээс буулгах байгууламж				
2.1	Байгууламж	тэгш талбай, суваг		тайлбар	
		ослын сав		ш, м <sup>3</sup>	
		буулгах худаг		тайлбар	
		Шүүр тунгаагуур		ш	
		хаалт		ш	
		газардуулга		тайлбар	
		гэрэлтүүлэг		ш, кВт	
3.	Авто эстакад				
3.1	Байгууламж	саравч		ш	
		тэгш талбай		м <sup>2</sup>	
		шат, тавцан		ш, м	
		гэрэлтүүлэг		ш, вт	
3.2	Ачих төхөөрөмж	нийт тоо		ш	
		насос		ш	
		хаалт		тайлбар	
		шүүр тунгаагуур		ш	
		шингэний тоолуур		ш	
		газардуулга		тайлбар	
		илүүдлийн сав		ш, м <sup>3</sup>	
4.	Насос станц				
4.1	Насос	буулгах	тоо		
			марк		
			м <sup>3</sup> /цаг		
		ачих	тоо		
			марк		



			м <sup>3</sup> /цаг	
4.2	Барилга	үндсэн хийц	тайлбар	
		агааржуулалт	тайлбар	
		гэрэлтүүлэг	тайлбар	
		халаалт		
5.	Сав парк, шугам хоолой			
5.1	Сав	үйлдвэрлэсэн улс	тайлбар	
		тоо	ш	
		байрлал	тайлбар	
		нийт багтаамж	м <sup>3</sup>	
5.2	Байгууламжууд	далан,	хөрс, бетон	
		талбай	хөрс, бетон	
		суваг шуудуу	тайлбар	
		ослын сав	ш, м <sup>3</sup>	
5.3	Технологийн шугам хоолой	урт	A-80	м
			Аи-92	м
			ДТ	м
			ТС-1	м
		диаметр	A-80	мм
			Аи-92	мм
			ДТ	мм
			ТС-1	мм
6.	Бусад байгууламжууд			
6.1	Талбайн гэрэлтүүлэг	тэсрэлтийн хамгаалалттай	ш кВт	
		суурин	тоо	
			Вт	
6.2	Гал унтраах багаж, тоног төхөөрөмж	усан сан	м <sup>3</sup>	
		хөөсний нөөц	тн	
		хөргөлтийн систем	тайлбар	
		хөөсний систем	тайлбар	
		ослын дохиолол	тайлбар	
		галын анхан шатны багаж, хэрэгсэл	/хавсралтаар/	
6.3	Савласан ГТБ хадгалах байр	барилга	м <sup>3</sup>	
		талбай	м <sup>2</sup>	
6.4	Цуглуулах, ууршуулах, цэвэрлэх байгууламж		тайлбар	





6.5	Дохиолол, камер, харуул хамгаалалт	тайлбар	
6.6	Хашаа	тайлбар	
7.	Чанарын шинжилгээний лаборатори		
7.1	өөрийн	итгэмжлэгдсэн	тайлбар
7.2	Зөөврийн	баталгаажуулсан	тайлбар
7.3	гэрээт	итгэмжлэгдсэн	тайлбар
8.	ГТБ-ий хэмжил, тооцоолол, мэдээллийн автоматжуулалт	тайлбар	
	Дүгнэлт	тайлбар	

Жич:

1. Онгоцны шатахууны агуулахын хувьд олон улсын нислэгийн нийгэмлэгээс гаргасан зааврын шаардлагыг үндэслэж тодорхойлолт ирүүлнэ.

ГТБА эзэмшигчийг төлөөлж:


Гарын үсэг \_\_\_\_\_

Овог нэр \_\_\_\_\_

Албан тушаал \_\_\_\_\_

Он, сар, өдөр \_\_\_\_\_

Үзлэгийн ажлын хэсэг:



# ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХЫН

## САВ ПАРКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эзэмшигчийн нэр: \_\_\_\_\_

ГТБА-ын байршил: \_\_\_\_\_

ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл: \_\_\_\_\_

Удирдлагын нэр, албан тушаал: \_\_\_\_\_

Д/д	Савны төрөл	Савны дугаар	Тоо	Хадгалах газрын тосны бүтээгдэхүүн	Тайлбар
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					

ГТБА эзэмшигчийг төлөөлж:


Гарын үсэг \_\_\_\_\_

Овог нэр \_\_\_\_\_

Албан тушаал \_\_\_\_\_


Он, сар, өдөр \_\_\_\_\_

Үзлэгийн ажлын хэсэг:





Уул уурхайн сайдын 2013 оны  
 08 сарын 09-ний өдрийн 171 дүгээр  
 тушаалын 17-р хавсралт



**ШИНГЭРҮҮЛСЭН ШАТДАГ ХИЙН АГУУЛАХЫН ТОДОРХОЙЛОЛТ** УХА0380

Эзэмшигчийн нэр: \_\_\_\_\_

ГТБА-ын байршил: \_\_\_\_\_

ГТБА-ын зориулалт /ГТБ-ий нэр, төрөл/ : \_\_\_\_\_

Удирдлагын нэр, албан тушаал: \_\_\_\_\_

Холбогдох утас: \_\_\_\_\_

д/д	ХЦС-Н хийц, тоног төхөөрөмж, элемент	Хэмжих нэгж	Тодорхойлолт, үзүүлэлт хүчин чадал
1	Газар эзэмших гэрчилгээний дугаар, эзэмших газрын хэмжээ	га	
2	Бусад барилга байгууламжаас алслагдсан байдал	м	
3	Ашиглалтанд орсон он		
4	Зураг төслийн шипр, дугаар он, сар, зураг төслийг болон барилга угсралтын ажил гүйцэтгэсэн байгууллага		
5	Вагонцистерн буулгах байгууламжийн тодорхойлолт	Шат давцан /тоо,урт/	ш/м
		Коллектор	/байгаа, эсэх/
		Гэрэлтүүлэг /тоо,х/ч/	ш/вт
		Шүүр тунгаагуур	ш
		Хий алдагдал мэдрэгч	ш
	Шингэн фазын тоолуур	ш	
6	Нэг удаа хүлээн авах хүчин чадал /вагонцистерн/	тоо	
7	Газардуулга /аянга зайлуулагч/	ш	
8	Хий алдалтыг мэдрэх систем	Дохиололын тоо	ш
		Хяналтын самбар	ш
		Дуут дохио өгөгч	ш
		Гэрлэн дохио өгөгч	ш
9	Технологийн шугам хоолой	Урт	Хийн фаз
			Шингэн

Бүртгэлийн дугаар ...187.....  
 МОНГОЛ УЛСЫН  
 УУЛ УУРХАЙН ЯАМ  
 ХУУЛБАР ҮНЭН  
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг  
 М. Ууганчимт  
 2013 оны 11 сарын 20-ний өдөр

		Диаметр	фаз Хийн фаз Шингэн фаз	мм мм		
10	Сав	Үйлдвэрлэсэн улс				
		Багтаамж			м <sup>3</sup>	
		Тоо ширхэг			ш	
		Хөргөлтийн систем			/байгаа, эсэх/	
		Манометр			ш	
		Түвшин хэмжигч			ш	
		Аваарын хаалт			ш	
		Хамгаалах клапан			ш	
		Термометр			ш	
		Хүнд үлдэгдлийн цорго			ш	
		Шүүр тунгаагуур			ш	
11	Автоцистернд ачих тоноглол	Хийн фаз	голч	мм		
			урт	м		
		Шингэн фаз	голч	мм		
			урт	м		
		Шингэний тоолуур			ш	
Шүүр тунгаагуур			ш			
12	Ачих тоноглолын удирдлага	Бүрэн ба хагас автомат				
13	Компрессорын станц	Хүлээн авах компрессор	Тоо	ш		
			Марк			
			Хүчин чадал			
		Ачих насос	Тоо	ш		
			Марк			
			Хүчин чадал			
14	Баллон цэнэглэх төхөөрөмж	Үйлдвэрлэсэн улс				
		Ашиглалтанд орсон он				
		Хүчин чадал				
		Тоо хэмжээ			ш	
15	Гал унтраах багаж, тоног төхөөрөмж	Усан сан			м <sup>3</sup>	
		Хөргөлтийн систем			/байгаа, эсэх/	
		Галын хошуу			ш	
		Галын хор			ш	
		Галын усны насос			ш	

Бүртгэлийн дугаар ...137.....

МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

М. Урагчимт  
2015 оны 11 сарын 10-ний өдөр



16	Хашааны тухай тодорхойлолт	Хийсэн материал		үгээр тайлбарлаж бичих	
17	Савласан бүтээгдэхүүнийг хадгалах саравчтай талбай, битүү агуулахтай эсэх	Багтаамж, тоо		үгээр тайлбарлаж бичих	
18	Гэрэлтүүлэг	Талбайн	тоо	ш	
		Прожектор	тоо	ш	
19	Төмөр замын салааны урт			м	
20	Сав паркын далангийн тодорхойлолт			үгээр тайлбарлаж бичих	
21	Холбоо			үгээр тайлбарлаж бичих	
22	Хяналтын камер			ш	
23	Газар хөдлөлтийг мэдрэгч			ш	
24	Хаалт			ш	

ГТБА эзэмшигчийг төлөөлж:


Гарын үсэг \_\_\_\_\_

Овог нэр \_\_\_\_\_


Албан тушаал \_\_\_\_\_

Он, сар, өдөр \_\_\_\_\_

Үзлэгийн ажлын хэсэг:



Уул уурхайн сайдын 2013 оны  
08 сарын 29-ний өдрийн 171 дүгээр  
тушаалын 21-р хавсралт



### ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Шатахуун түгээх станцыг эзэмшигч: \_\_\_\_\_  
 Шатахуун түгээх станцын байршил: \_\_\_\_\_  
 Шатахуун түгээх станцын удирдлага: \_\_\_\_\_  
 Холбогдох утас: \_\_\_\_\_  
 Огноо: \_\_\_\_\_

д/д	Нэг. Эрх зүйн бичиг баримтууд	Бүрдэл	
1.	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, газрын хэмжээ		
2.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, огноо		
3.	Батлагдсан зураг төслийн шифр, боловсруулсан байгууллага, огноо		
4	Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн байгууллага, огноо		
д/д	Хоёр. Техник, тоног төхөөрөмжийн шаардлагууд	үзүүлэлтүүд	Дүн /0-100/
1	Жижиглэн борлуулах шатахууны төрөл, тус бүрийн савны багтаамж:		
2	Бусад объектоос алслагдсан зай хэмжээ		
3	Сав паркийн байрлал		
4	Шатахуун хүлээн авах тэгш талбай, асгарсан шатахуун цуглуулах суваг		
5	Шатахуун хүлээн авах худаг		
6	Бүтээгдэхүүний төрөл тус бүрийн хаалт		
7	Бүтээгдэхүүний төрөл бүрт зориулалтын шүүр		
8	Автоцистерний газардуулга		
9	Буулгах хоолойн амны битүүмжлэлийг хангах		
10	Савны амьсгалах клапангууд бүрэн		

Бүртгэлийн дугаар 137  
 МОНГОЛ УЛСЫН  
 УУЛ УУРХАЙН ЯАМ  
 ХУУЛБАР ҮНЭН  
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг  
*Ш. Чингис*  
 2013 оны 11 сарын 20 ний өдөр



11	Амьсгалах клапангууд хэвийн ажиллах		
12	Гал хамгаалагч бүрэн		
13	Хэмжих люк бүрэн		
13	Зарлагын хоолойн задвижек бүрэн		
14	Зарлагын хоолойн задвижек ажиллагаатай		
15	шаардлага хангасан аянга зайлуулагч		
17	Газардуулгын сүлжээ хийгдсэн		
18	Шаардлага хангасан савны паркийн ба үерийн суваг		
19	Бүтээгдэхүүний төрөл тус бүрт түгээгүүртэй		
20	Түгээгүүрийн арал стандартын шаардлага хангасан		
21	Түгээгүүрийн хөдөлгүүрт давтан газардуулга хийсэн		
22	Шаардлага хангасан түгээгчийн байр		
23	ШТС-ын зам талбай хатуу хучилттай		
24	Цэвэрлэх байгууламж		
25	Цэнэглэх талбайн саравч		
26	Цахилгааны тэжээлийн холболт дүрмийн шаардлага хангах		
27	ГТБ-ий үнийн самбар		
<i>Нэгдүгээр хэсгийн дүн</i>			%
<b>д/д</b>	<b>Гурав. Технологийн шаардлагууд</b>	<b>тайлбар, үзүүлэлтүүд</b>	<b>Дүн /0-100/</b>
1	Хүлээн авсан шатахуунд дагалдах шинжилгээний паспорт		
2	Шатахуун хүлээн авсан тооцоо бүртгэл		
3	Савны шатахуунд сард 1 удаа шинжилгээ хийсэн баримт		
4	Аянга зайлуулагч, газардуулгыг жилд 2 удаа хэмжсэн баримт		
5	Шатахууны төрөл бүрт тохирох денсиметр		

Бүртгэлийн дугаар ...137.....

**МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

...*М. Уриангима*...  
2013 оны 11 сарын 20 ний өдөр

6	Мерник /10л/		
7	Сүмбэн метр /3м/		
8	Шаардлага хангасан дээж авах бортого		
9	Автоцистернээс ачаа буулгах үеийн ивүүр		
10	Үйлчилгээний орчны ариун цэвэр		
11	Сав,шугам хоолойн битүүмжлэлийн шаардлага хангасан байдал		
12	ГТБ-ээр бохирдсон зам талбайг цэвэрлэх арга хэмжээний хэлбэрүүд		
13	Хээрийн түймрээс хамгаалах зурвасыг стандартын дагуу татсан эсэх /Ой, хээрийн түймэр гардаггүй бүсэд орших ШТС-д энэ үзүүлэлт хамаарахгүй/		
14	Анхан шатны бүртгэлүүдийн хөтлөлт		
15	Мэргэжлийн боловсон хүчний хангалт		
16	Дохиолол, харуул хамгаалалт		
17	ГТБ-ий хэмжил, тооцоолол, мэдээллийн автоматжуулалт		
<b>Хоёрдугаар хэсгийн дүн</b>			%
<b>Нийт дүн</b>			%

ШТС эзэмшигчийг төлөөлж:


Гарын үсэг \_\_\_\_\_

Овог нэр \_\_\_\_\_

Албан тушаал \_\_\_\_\_

Он, сар, өдөр \_\_\_\_\_

Үзлэгийн ажлын хэсэг:





Уул уурхайн сайдын 2013 оны  
08. сарын 29.-ний өдрийн 177 дүгээр  
тушаалын 6.-р хавсралт

Маягт 4

УХА0380

**АВТОМАШИНЫГ ХИЙГЭЭР ЦЭНЭГЛЭХ  
СТАНЦЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

АХЦС-ын эзэмшигч: \_\_\_\_\_  
АХЦС-ын байршил: \_\_\_\_\_  
АХЦС-ын удирдлага: \_\_\_\_\_  
Холбогдох утас: \_\_\_\_\_  
Огноо: \_\_\_\_\_

д/д	Нэг. Эрх зүйн бичиг баримтууд	Бүрдэл	
1.	Газар эзэмших гэрчилгээний дугаар, огноо, газрын хэмжээ		
2.	Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, огноо		
3.	Батлагдсан зураг төслийн шифр, боловсруулсан байгууллага, огноо		
4	Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийсэн байгууллага, огноо		
д/д	Хоёр. Техник, тоног төхөөрөмжийн шаардлагууд	үзүүлэлтүүд	Дүн /0-100/
1	Савны багтаамж		
2	Хийн баллон хадгалдаг болон цэнэглэдэг эсэх		
3	Бусад объектоос алслагдсан зай хэмжээ		
4	Мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хий Хадгалах савны металл хийцийн оношлогоо хийлгэсэн.		
5	Хий хадгалах даралтат савыг улсын бүртгэлд хамруулж ашиглах зөвшөөрөл авсан.		
6	Хий хадгалах савыг мөнгөлөг цагаан өнгөөр будсан, анхааруулга бичиглэлтэй.		
7	Хий хадгалах сав нь усан хөргөлттэй /бороожуулагч/		
8	Хөргөлтийн болон гал унтрах зориулалтын усан сантай.		
9	Хий хадгалах сав нь бүрэн тоноглогдсон.		
10	Аянга зайлуулагч газардуулгын эсэргүүцлийг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлсэн.		

Бүртгэлийн дугаар 137

МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

*М. Уриангитов*


2013 оны 11 сарын 20 ний өдөр

11	Хий хадгалах сав, шугам хоолойн хамгаалах хавлагийг туршиж шалган акт үйлдсэн.		
12	Хянах, хэмжих багаж хэрэгсэл улсын баталгаатай.		
13	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан.		
13	Чанарын хувьд олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг импортлосон		
14	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай бөгөөд мөрдөж ажилладаг.		
15	Газардуулгын сүлжээ хийгдсэн		
17	Шаардлага хангасан аянга зайлуулагч		
18	Автоцистерний газардуулга		
19	Шаардлага хангасан түгээгчийн байр		
20	АХЦС-ын зам талбай хатуу хучилттай		
21	Цэнэглэх талбайн саравч		
22	Цахилгааны тэжээлийн холболт дүрмийн шаардлага хангах		
23	ГТБ-ий үнийн самбар		
24	Хүлээн авсан ШШХ-н дагалдах шинжилгээний паспорт		
25	ШШХ хүлээн авсан тооцоо бүртгэл		
26	Үйлчилгээний орчны ариун цэвэр		
27	Мэргэжлийн боловсон хүчний хангалт		
28	Дохиолол, харуул хамгаалалт		
29	ГТБ-ий хэмжил, тооцоолол, мэдээллийн автоматжуулалт		
<b>Нийт дүн</b>			%

ШТС эзэмшигчийг төлөөлж:


Гарын үсэг \_\_\_\_\_  
Овог нэр \_\_\_\_\_  
Албан тушаал \_\_\_\_\_  
Он, сар, өдөр \_\_\_\_\_

Үзлэгийн ажлын хэсэг:





Уул уурхайн сайдын 2013 оны  
0.8 сарын 29-ний өдрийн 17/ дүгээр  
тушаалын 6.-р хавсралт  
Маягт 5



### Импортын мэдээ

ААН-ийн нэр: .....

Тайлант хугацаа: 20.... оны .....-р сарын ....-с 20.... оны .....-р сарын .... өдөр

Д/Д	Нийлүүлэгч эх үүсвэр		Бүтээгдэхүүний төрөл	Бүтээгдэхүүний хэмжээ		Огноо	Нэгж үнэ \$ тонн	Импортолсон боомт
	Улс	Компани						
				жижиглэн				
				бөөн				
				жижиглэн				
				бөөн				
				жижиглэн				
				бөөн				
				жижиглэн				
				бөөн				
				жижиглэн				
				бөөн				
	<b>Нийт</b>			жижиглэн				
	<b>Нийт</b>			бөөн				

Анхаарах:

- Газрын тосны бүтээгдэхүүний импортын мэдээг нийлүүлэгч эх үүсвэр тус бүрээр, бүтээгдэхүүний төрөл, бүтээгдэхүүний хэмжээ, импортолсон боомт бүрээр тус бүр гаргаж сар бүрийн 5-ны дотор ГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
- Бүтээгдэхүүний импортолсон хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээг гаргасан:

.....


Албан тушаал,

Овог нэр,


Гарын үсэг

Тэмдэг

.....он .....сар .....өдөр



Уул уурхайн сайдын 2013 оны  
 0.8 сарын 29-ний өдрийн /7/ дүгээр  
 тушаалын 7.-р хавсралт



Маяг 6

**Бөөний борлуулалтын мэдээ**

ААН-ийн нэр: .....

Тайлант хугацаа: 20..... оны .....-р сарын ....-с 20..... оны .....-р сарын .... өдөр

Д/д	Огноо	Хот, аймаг	Борлуулалт /тонноор/					Нийт борлуулалт
			90-ээс доош октантай автобензин	90-ээс дээш октантай автобензин	Дизелийн түлш	Онгоцны түлш	Шингэрүүлсэн шатдаг хий	
1								
2								
3								
Нийт								

Анхаарах:


1. Бөөний борлуулалтын тухайн сарын мэдээг аймаг хот тус бүрээр гаргаж дараа сарын 5-ны дотор ГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
2. Бөөний борлуулалтын тайланг үйл ажиллагаа явуулж байгаа хот, аймаг тус бүрээр гаргах ба борлуулсан хэмжээг тонноор тооцож шивнэ.

Мэдээг гаргасан:

.....


Албан тушаал, Овог нэр, Гарын үсэг Тэмдэг

.....он .....сар .....өдөр





Уул уурхайн сайдын 2013 оны  
08 сарын 29-ний өдрийн 71 дүгээр  
тушаалын 8-р хавсралт



### Жижиглэнгийн борлуулалтын мэдээ

ААН-ийн нэр: .....

Тайлант хугацаа: 20..... оны .....-р сарын ....-с 20..... оны .....-р сарын .... өдөр

Д/д	Огноо	Хот, аймаг	Борлуулалт /тонноор/					Нийт борлуулалт
			90-ээс доош октантай автобензин	90-ээс дээш октантай автобензин	Дизелийн түлш	Онгоцны түлш	Шингэрүүлсэн шатдаг хий	
1								
2								
3								
Нийт								

#### Анхаарах:

1. Жижиглэнгийн борлуулалтын тайланг тухайн сард аймаг хот бүрээр гаргаж дараа сарын 10-ны дотор ГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
2. Жижиглэнгийн борлуулалтын тайланг үйл ажиллагаа явуулж байгаа хот, аймаг тус бүрээр гаргах ба борлуулсан хэмжээг тонноор тооцож шивнэ.

#### Мэдээг гаргасан:

.....


Албан тушаал,


Овог нэр,

Гарын үсэг

Тэмдэг

.....он .....сар .....өдөр





Уул уурхайн сайдын 2013 оны  
0.8 сарын 2-ний өдрийн /71/ дүгээр  
тушаалын 9-р хавсралт

Маягт 8  
УХА0380

### Үлдэгдлийн мэдээ

ААН-ийн нэр: .....

Тайлант хугацаа: 20..... оны .....-р сарын .....-с 20..... оны .....-р сарын ..... өдөр

Агуулах, ШТС-ын байршил	Агуулахын үлдэгдэл /тн/				ШТС-ын үлдэгдэл /тн/				Агуулахын үнэ төг/лигр				ШТС-ын үнэ төг/лигр				
	Н-80	Р-92	П-95,98	ШШХ ДТ	ШШХ ОТ	Н-80	Р-92	П-95,98	ШШХ ДТ	Н-80	Р-92	П-95,98	ШШХ ДТ	Н-80	Р-92	П-95,98	ШШХ ДТ
Хот, аймаг																	
Сум, дүүрэг																	
Нийт																	

ШШХ- Шингэрүүлсэн шатдаг хий, ОТ- Онгоцны тулш

Анхаарах:

1. Үлдэгдлийн тайланг долоо хоног бүрийн Мягмар гаригт хот, аймаг бүрээр гаргаж ГТГ-т эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлнэ.
2. Үлдэгдэл, үнийг тухайн өдрийн дүнгээр шивнэ.
3. Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тухайн агуулахад хадгалагдаж байгаа үлдэгдэл болно.
4. Тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь тухайн аймаг хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт ШТС-т хадгалагдаж байгаа үлдэгдэл болно.

Мэдээг гаргасан:

..... Овог нэр, Тэмдэг  
Албан тушаал, Гарын үсэг .....ОН .....сар .....өдөр

Бүртгэлийн дугаар 137

МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2013 оны 11 сарын 20 ний өдөр



Уул уурхайн сайдын 2013 оны  
0.8 сарын 20-ний өдрийн 171 дүгээр  
тушаалын 10-р хавсралт

**Мэдээ тайлан ирүүлэх хуваарь**

№	Мэдээллийн нэрс	Хугацаа	Газрын тосны газрын арьс хэлтэст хүргүүлэх	Танилцуулах албан тушаалтан
1	Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл нөөцийн мэдээ	7 хоног бүрийн 2 дахь өдөр	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
2	Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийн мэдээ, төг /ШТС-аар, хот, аймгаар/	7 хоног бүрийн 2 дахь өдөр	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
3	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний үнийн мэдээ, төг /агуулах, хот, аймгаар/	7 хоног бүрийн 2 дахь өдөр	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
4	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн борлуулалтын мэдээ	Сар бүрийн 5-ны дотор	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортлолж буй мэдээг нийлүүлэгч эх үүсвэрээр, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, хилийн үнэ, импортолсон боомт бүрээр тус бүр гаргаж сар бүрийн 5-ны дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан хүргүүлэх	Сар бүрийн 5-ны дотор	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
6	Бөөний борлуулалтын тайланг тухай сард аймаг хот бүрээр гаргаж эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан Газрын тосны газарт хүргүүлнэ.	Сар бүрийн 5-ны дотор	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
7	Жижиглэнгийн борлуулалтын тайланг тухайн сард аймаг хот бүрээр гаргаж тухайн улирлын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан Газрын тосны газарт хүргүүлнэ.	Сар бүрийн 10-ны дотор	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
8	Гадаад захиалгын мэдээ	Сар бүрийн 5-ны дотор	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ
9	Компанийн нөөцийн шатахууны мэдээ	Сар бүрийн 5-ны дотор	ГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн хэлтэст	Уул уурхайн сайд, ҮАБЗөвлөл, ГТГ, ТЕГ, ШӨХТГ

Бүртгэлийн дугаар ..... 157

**МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙН ЯАМ  
ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

*М. Сүрэншар*

2013 оны 01 сарын 20-ний өдөр